



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014. 02. 10. №08/156
ЧАГ-РАГ/2013/06-14

Илүү олгосон урамшууллыг улсын
төсөвт буцаан төвлөрүүлэх тухай

САНГИЙН САЙД Ч.УЛААН,
ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД Х.БАТТУЛГА НАРТ

Нөөцийн мах бэлтгэн, нөөцөлж борлуулах үйл ажиллагааны үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитаар махыг ангилан савласны болон хорогдлын зардлыг хяналгүйгээр нийт 2,698,832.613 /хоёр тэрбум зургаан зуун ерэн найман сая найман зуун гучин хоёр мянга зургаан зуун арван гурван/ төгрөгийг илүү санхүүжүүлсэн зөрчил илэрлээ. Үүнд:

1. 7,373.6 тонн махыг гулуузаар борлуулсан байхад 589,888,000 төгрөгийн ангилан савласны зардлыг Жаст Агро, Баатарууд тэнгэр, Эрдмийт ХХК-иудад,
2. Хадгалсан маханд гүйцэтгэлээр 10,780.386 төгрөгийн хорогдлын зардлыг санхүүжүүлэхээр байтал нийт бэлтгэсэн 9,421.0 тонн махаар тооцож 2,108,944,613 төгрөгийг Жаст Агро ХХК-д тус тус илүү олгосон байна.

Энэ нь нөөцийн махны менежментийн гэрээний 5.2-т "...1 кг тутамд жижиглэж, ангилан савлах зардлыг 80, хорогдлын зардлыг 225 төгрөгөөр...", 5.5-д "...нөөцийн махыг жижиглэн худалдаанд нийлүүлж дууссаны дараа гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гүйцэтгэгчид шилжүүлнэ" гэж тусгасан, Сангийн болон УХААС-ын 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 100/A70 дугаар тушаалаар 2013 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан бэлтгэн нөөцөлж худалдан борлуулсан махны 1 кг тутамд олгох урамшууллыг тогтоож аж ахуйн нэгжүүдэд олгох, түүнд хяналт тавьж ажиллахыг УХААЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газар, СЯ-ны Төсвийн бодлого төлөвлөлтийн газарт даалгасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..." гэж заасныг үндэслэн илүү олгосон санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 2014 оны 7 дугаар сарын 1-ний дотор хариу мэдэгдэх албан шаардлагыг хургуулж байна.

АХЛАХ АУДИТОР



У.БАЯРМАА